

*Санхүүгийн зохицуулах хорооны  
.... оны .... дүгээр сарын ....-ний өдрийн  
.... дүгээр тогтоолын хавсралт*

## **АРАВДУГААР ХАВСРАЛТ**

### **ГАДААД УЛСАД САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРАА НЭЭХ, ТҮҮГЭЭР ДАМЖУУЛАН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЖУРАМ**

#### **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 14.2.10 дахь заалтын дагуу олгосон тусгай зөвшөөрөл бүхий даатгагчийн гадаадад салбар, төлөөлөгчийн газар байгуулах үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотойгоор үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гадаад улсад байгуулагдах даатгалын салбар, төлөөлөгчийн газар нь Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны (цаашид Хороо гэх) хяналт, зөвшөөрлөөр үйл ажиллагаагаа явуулна.

#### **ХОЁР. ГАДААД УЛСАД САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР НЭЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

2.1. Даатгалын компани гадаад улсын нутаг дэвсгэрт өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг нээж ажиллуулахдаа Хорооноос зөвшөөрөл авна. Хороо дараах шалгуур үзүүлэлтийг үндэслэн зөвшөөрөл олгоно. Үүнд:

2.1.1. Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх даатгалын компани (цаашид даатгагч гэх) нь тухайн улсад даатгалын үйл ажиллагаа явуулах төлөвлөгөөтэй байх;

2.1.2. Даатгагч нь даатгалын чиглэлээр мэргэшсэн боловсон хүчинтэй байх;

2.1.3. Даатгагч нь Хорооны 2007 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

2.1.4. Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ 1 тэрбум төгрөгөөс дээш байх;

2.1.5. Даатгагч нь салбаруудтайгаа мэдээллийн нэгдсэн нэг сүлжээнд холбогдож, мэдээллийн электрон баазтай болсон байх;

2.1.6. Даатгагч нь 5-аас доошгүй жилийн даатгалын бизнесийн дадлага, туршлагатай байх.

#### **ГУРАВ. ХОРООНООС САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ТАТГАЛЗАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ**

3.1. Даатгагч нь салбар, төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл авахдаа дараах материалыг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

3.1.1. Салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай даатгагчийн хүсэлт;

3.1.2. Салбар, төлөөлөгчийн газартай байгуулах гэрээний загвар;

3.1.3. Салбар, төлөөлөгчийн газрын удирдлагын тодорхойлолтыг "Ердийн даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын 3 дугаар хавсралтаар гаргаж, иргэний үнэмлэхийн баталгаажуулсан хуулбарын хамт ирүүлэх;

3.1.4. Тухайн салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

3.1.5. Салбар, төлөөлөгчийн газрын дотоод хяналтын болон бусад үйл ажиллагааг зохицуулах журам;

3.1.6. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах орон байр, үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж, компьютер, техник хэрэгсэл, программ хангамжийн талаарх мэдээлэл;

3.1.7. Шаардлагатай гэж үзвэл Хороо нэмэлт материалыг шаардаж болно.

3.2. Хороо энэ журмын 3.1-д дурдсан баримт бичгийг хянан үзэж, салбар, төлөөлөгчийн газар байгуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, үйлчлүүлэгчдэд хохирол учруулахгүй, боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, программ хангамж нь тухайн салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангахаар байна гэж үзвэл зөвшөөрөл олгох шийдвэрийг Хорооны дарга гаргана.

3.3. Даатгагч нь салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах, үйл ажиллагааг хязгаарлах, өөрчлөн байгуулах /нэгтгэх, нийлүүлэх, салгах, тусгаарлах, өөрчлөх/, байршлыг нь өөрчлөх /хооронд нь солих, шилжүүлэх/ тухай бүрд шийдвэр гаргаж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Хороонд ирүүлж, зөвшөөрөл авсаны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

3.4. Даатгагчийн салбартай холбоотой Хорооны даргын шийдвэр болон Хорооноос баталсан "Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоох тухай журам"-д заасны дагуу Хорооны дансанд төлсөн хураамжийн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтанд салбарын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулна.

3.5. Даатгагчийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 5 хоногийн дотор энэ тухай тэмдэглэл хийнэ. Үүнд:

3.5.1. Салбар татан буулгах талаар гарсан тухайн даатгагчийн удирдлагын шийдвэр;

3.5.2. Гадаад улсын харьяалах хяналтын байгууллагаас гаргасан шийдвэр;

3.5.3. Хороо нь тухайн даатгагчийн салбар, төлөөлөгчийн газар санхүүгийн хүндрэлд орсон, холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй буюу тухайн салбарын санхүүгийн байдал даатгагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл салбарын үйл ажиллагааг зогсоох тухай саналаа гадаад улсын харьяалах хяналтын байгууллагад мэдэгдсэний үндсэн дээр олгосон зөвшөөрлөө хүчингүй болгох;

### 3.5.4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

## ДӨРӨВ. ДААТГАГЧААС ГАДААД УЛСАД БАЙГУУЛСАН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТАЛААР ХОРООНД ТАЙЛАГНАХ

4.1. Даатгагч гадаад улсаас салбар төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрлийг авснаас хойш ажлын 10 хоногийн дотор Хороонд салбар, төлөөлөгчийн газрын албан ёсны хаяг, холбоо барих утас, эрх бүхий этгээдийн талаар албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдлийг үндэслэн Хороо даатгагчийн тухайн салбар, төлөөлөгчийн газрыг нэгдсэн бүртгэлд авч, энэ тухай даатгагчид мэдэгдэнэ.

4.2. Даатгагч нь салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлнэ.

4.3. Даатгагч нь салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл авахтай холбоотой ирүүлсэн материалд өөрчлөлт орсон тухай бүрд Хороонд мэдэгдэнэ.

4.4. Гадаадын салбар, төлөөлөгчийн газар нь санхүүгийн тайлан балансаа хөндлөнгийн аудитаар заавал баталгаажуулсан байна.

## ТАВ. ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1. Хороо гадаад улсад даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын даатгагчийн салбар, төлөөлөгчийн газрын бүртгэл хөтөлнө.

5.2. Хороо гадаад улсад байгуулагдсан даатгалын салбар төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавихдаа гадаад улсын даатгалын хяналтын байгууллагатай хамтарч ажиллана.

5.3. Хороо гадаадын хяналтын байгууллагад даатгагчийн талаар тодорхой мэдээллийг өгч болно.

5.4. Хороо олгосон зөвшөөрөл болон тухайн салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрээ гадаадын хяналтын байгууллагад албан ёсоор хүргүүлж болно.

5.5. Хороо даатгагчийн төлбөрийн чадварын байдалд байнгын хяналт тавина. Хэрэв төлбөрийн чадвар хангалтгүй, тухайн гадаад улсад явуулж буй бизнесийг удирдаж чадахгүй, хөрөнгийн чадавхи хүрэлцээгүй болсон бол гадаадад тухайн бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг зогсоож болно.

5.6. Хороо гадаад улс дахь даатгалын салбарын болон төв компанийн тайлан, түүний дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавина.

5.7. Хороо даатгалын салбарын санхүүгийн тайлангийн бодитой эсэхэд бие даан шалгалт хийх, эсвэл энэ талаар гадаадын байгууллагатай зөвшилцөх, мөн гадаадын байгууллагад шалгуулах хүсэлтээ тавьж болно.

5.8. Хороо даатгалын салбар, төлөөлөгчид тавигдах шаардлага, авах арга хэмжээ өөрчлөгдсөн бол энэ талаар гадаадын хяналтын байгууллагад мэдээлнэ.

5.9. Хороо хэрэв гадаадын хяналтын байгууллагын хяналт тавих стандарт нь бодитой бус гэж үзвэл гадаадын хяналтын байгууллагатай энэ талаар зөвшилцөнө.

#### ЗУРГАА. БУСАД

6.1. Энэхүү журмыг зөрчсөн даатгагч нь хуулийн хариуцлага хүлээнэ.

---ooOoo---